



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх, данснаас хасах зөвшөөрөл өгөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татан буугдсан "Засгийн газрын хэвлэх үйлдвэр" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 117,349,057.30 (нэг зуун арван долоон сая гурван зуун дөчин есөн мянга тавин долоон төгрөг гучин мөнгө) төгрөгийн үнэ дүн бүхий авлага, хөрөнгийг хавсралтад заасны дагуу Төр засгийн үйлчилгээ эрхлэх газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Энэхүү тогтоолын хавсралтад заасан бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгөөс нийт 9,373,858.69 (есөн сая гурван зуун далан гурван мянга найман зуун тавин найман төгрөг жаран есөн мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3.Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга Ж.Тамирт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2.Авлагын шаардах эрхийг шилжүүлэх, тооцоо нийлэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

3.3 Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002960
10-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны ...07... дугаар сарын...17.....өдрийн
152 дугаар тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ГАЗАРТ БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн данс	Балансын дүн /төгрөг/
1	Авлага	34,750,000.00
2	Бараа материал	82,599,057.30
	Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	117,349,057.30